



**МОНГОЛ УЛСЫН
СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ
ТОГТООЛ**

2021 оны 01 сарын 22 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

**Цахимаар санал авах ажлыг
зохион байгуулах тухай**

Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсэг, Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.11 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 226 дугаар тогтоолыг үндэслэн ТОГТООХ нь:

1.2021 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр товлогдсон Сонгуулийн ерөнхий хорооны хуралдаан хойшилсонтой холбоотойгоор уг хуралдаанаар хэлэлцэх хоёрдугаар асуудал буюу “Сонгуулийн ерөнхий хорооны дэргэдэх Мэдээллийн технологийн төвөөс ирүүлсэн хүсэлтийн тухай” асуудалтай холбоотойгоор гишүүдээс санал авах ажлыг цахим хэлбэрээр зохион байгуулсугай.

2.Зохион байгуулалтын арга хэмжээ авч, саналыг нэгтгэн танилцуулахыг Нарийн бичгийн дарга /Д.Даваа-Очир/, Ажлын алба /Д.Баяндүүрэн/ нарт тус тус даалгасугай.

ДАРГА

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



П.ДЭЛГЭРНАРАН

Д.ДАВАА-ОЧИР

00000002